



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

“Тохилог Чингэлтэй-2028” арга хэмжээ
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, дүүргийн нутаг дэвсгэрт иж бүрэн тохижилтын ажлыг хийх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, агаар, хөрсний бохирдлыг багасгах, авто замын түгжрэлийг бууруулах зорилго бүхий “Тохилог Чингэлтэй-2028” арга хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА

Т.УЛАМБАЯР

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 06 дугаар сарын 21-ны
өдрийн 20 дугаар тогтоолын хавсралт

“ТОХИЛОГ ЧИНГЭЛТЭЙ-2028” АРГА ХЭМЖЭЭ

Нэг.Нийтлэг үндэслэл

“Тохиллог Чингэлтэй-2028” арга хэмжээг боловсруулахдаа Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг тус тус үндэслэн боловсруулав.

Хоёр.Арга хэмжээний зорилго

Дүүргийн иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, дүүргийн нутаг дэвсгэрт иж бүрэн тохижилтын ажлыг хийх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, агаар, хөрсний бохирдлыг багасгах, авто замын түгжрэлийг бууруулахад арга хэмжээний зорилго оршино.

Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай дахь тохижилтын ажлыг нэмэгдүүлэх, ургамлан болон орчин үеийн шийдэл бүхий ногоон хашлага бий болгож тэдгээрийг арчилж хамгаалахад тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, аж ахуй нэгжийг сурталчилгааны бодлого, нийгмийн хариуцлагатай нь уялдуулж татан оролцуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг нэн тэргүүний зорилго болгон авч тусгав.

Дүүргийн оршин суугч иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцлийг хангахад юуны өмнө нутаг дэвсгэр дэх орон сууцны хороолол дундах бичил цэцэрлэгийн засвар шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэн арчлалтыг тухайн орчны сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаатай хамтран ажиллах гэрээгээр уялдуулан хариуцуулж ажиллах үүрэг чиглэл өгөх эрх зүйн орчинг судалж байна.

Дүүргийн нутаг дэвсгэрт нийт 137,5 км гол болон туслах авто зам, замын байгууламж байна. Авто замын байгууламжид замын ачаалал болон засвар үйлчилгээ хангалтгүй зэрэг шалтгаанаар жил бүр эвдрэл гэмтэл үүсдэг тул засвар шинэчлэлтийн ажлыг тухай бүрт нь хийж ажиллахаар тус арга хэмжээнд тусгалаа.

Нийтийн орон сууцуудын дээвэр, фасад, лифтний засвар үйлчилгээг Нийслэлийн Засаг даргын зүгээс өгсөн чиглэлийн хүрээнд “Тохиллог Чингэлтэй 2028” арга хэмжээнд багтаан засварлах ажлыг хийж хэрэгжүүлэн, 2027 он гэхэд дахин

эдгээр байруудын засварын ажиллагааг төсвийн мөнгөөр засварлахгүй байхаар шийдвэрлэн, 2025, 2026 онуудад нийт 42 дээвэр, 66 фасад 14 лифт засварын ажлын зураг төсөл болон ажлыг нийслэл, дүүргийн төсөвт суулгаж ажиллалаа.

Чингэлтэй дүүрэг нь гэр хорооллын 18 хороотой, агаарын бохирдол үүсгэгч эх үүсвэр буюу 3-15 кВт галлагаатай зуух 20180 бүртгэгдсэн, 15-100 кВт галлагаатай зуух 300 орчим бүртгэгдсэн нь шахмал түлш түлэхийг бууруулах болон сэргээгдэх эрчим хүч ашиглах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх зэрэг арга хэмжээг яаралтай авах шаардлагатай болохыг харуулж байна.

Дүүргийн хэмжээнд 1-24 дүгээр хорооны хэмжээнд нийт 12536 гэрэлтүүлэгтэй. Үүнээс эрчим хүчний шон дээр байрлуулсан гэрэлтүүлгүүдийг шинэчлэх, алсын удирдлага хийгдээгүй байршлуудад шинээр удирдлагатай самбар байршуулах ажлыг тус арга хэмжээнд тусгалаа.

Дүүргийн нутаг дэвсгэрт "Тохилог Чингэлтэй 2028" арга хэмжээг хэрэгжүүлсэнээр:

Дүүргийн иргэдийн ая тухтай амьдрах орчинг бүрдүүлэх, амралт чөлөөт цагаа өнгөрөөх бичил цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай байгуулах, иж бүрэн тохижилтын ажлыг хийх, ногоон байгууламжийг бий болгох, түүнийг арчлах, нөхөн сэргээх, нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх замаар иргэдэд ээлтэй хүрээлэн буй орчин бүрдүүлэх;

Дүүргийн нутаг дэвсгэрт ус, хөрс, агаарын бохирдлыг бууруулах, хог хаягдлыг багасгахад оновчтой төлөвлөлт, шуурхай зохицуулалтаар хангах, иргэдийн ухамсартай, ухаалаг зөв хэрэглээг бий болгох, хэвшүүлэх;

Дүүргийн нутаг дэвсгэрт зам, замын байгууламжийг нэмэгдүүлж, ашиглалт, засвар үйлчилгээг сайжруулан, дүүргийн иргэдийн ая тухтай зорчих нөхцлийг хангах, явган болон дугуйн замыг бий болгох, авто замын түгжрэлийг бууруулах;

Дүүргийн гудамж талбай, нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, ухаалаг системд холбож, гэрэлтүүлгийн ашиглагч байгууллагуудын үйл ажиллагаа болон хяналтыг сайжруулах;

Дүүргийн нутаг дэвсгэрт үерийн байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, үер, бороо, хөрсний усны аюул гамшгаас урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй, эрсдэлгүй амьдрах орчин нөхцлийг хангах боломжтой болох юм.

Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд жил бүрийн мод, ногоон байгууламжийн тооллогын ажлыг зохион байгуулах, мод тарих ажлыг зохион байгуулах, арчлалт хамгаалалтыг нэмэгдүүлэх;

Гурав.Арга хэмжээний зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

Зорилт 1: Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, дээвэр, фасад, инженерийн шугам, сүлжээг засварлаж, шинэчилэх, иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

1.1. Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засварын ажлыг хэрэгжүүлж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх;

1.2. Нийтийн зориулалттай орон сууцны фасад засварыг ажлыг хэрэгжүүлж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх;

1.3. Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, инженерийн шугам, сүлжээг засварлаж, шинэчлэх ажлыг хэрэгжүүлж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх;

Хүрэх үр дүн:

1.1. Байрны дулаан алдагдал буурч, цахилгаан эрчим хүчний хэрэглээ багасна.

1.2. Нийтийн орон сууцны өнгө үзэмж сайжирч, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлэмж дээшилнэ.

1.3. Оршин суугчдын гомдол хүсэлт буурч, төрд итгэх итгэл нэмэгдэж, сэтгэл ханамж сайжирч, төвийн хороодын орон сууцуудын оршин суугчдын амьдралын дээшилнэ.

Зорилт 2: Авто зам, замын гүүрэн байгууламж, үндсэн сүлжээ, тойрог болон туслах зам, замын ус зайлуулах шугам сүлжээний шинэчлэлтийн ажил, зам засварлах ажлуудыг хэрэгжүүлнэ.

2.1. Авто зам, замын байгууламж, үндсэн сүлжээ, тойрог болон туслах замыг нэмэгдүүлэх;

2.2. Авто замын гүүрэн байгууламжийн тоог нэмэгдүүлэх;

2.3. Авто замын ус зайлуулах шугам сүлжээ шинээр хийх болон шинэчлэх, засварлах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

2.4. Дүүргийн нутаг дэвсгэр дэх авто замын засвар шинэчлэлтийн ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

2.5. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг орчимд авто замын аюулгүй байдлыг хангасан цогц төсөл, арга хэмжээг санаачлан хэрэгжүүлэх;

2.6. Авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлж, авто зогсоолын тохижилтын ажлыг шинээр хийж гүйцэтгэх, газар дээрх болон доорх зогсоолыг төр-хувийн

хэвшлийн хамтын санхүүжилт, менежментийн зарчмаар барьж байгуулах ажлыг эрчимжүүлэх;

Хүрэх үр дүн:

2.1.Авто замын сүлжээг сайжруулж, тойрог болон туслах замыг нэмж барьснаар авто замын түгжрэлийг бууруулж, иргэдийн түгжрэлд зарцуулах амьдралын цаг хугацааг хэмнэнэ.

2.2.Авто замын гүүрэн байгууламж нэмэгдсэнээр авто замын төвлөрөл багасаж, иргэдийн түгжрэлд зарцуулах цаг буурна.

2.3.Авто замын болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээг сайжруулж, нэмэгдүүлснээр үерийн эрсдэл, авто замын эвдрэл гэмтлийг бууруулна.

2.4.Авто замын эвдрэл гэмтлийг засварлан сайжруулснаар авто замын зорчих хэсгийн аюулгүй байдал хангагдаж, авто ослоос урьдчилан сэргийлж, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5.Сургууль, цэцэрлэг, эмнэлэг орчмын авто замын аюулгүй байдлыг хангаснаар хүүхэд багачуудын сурч боловсрох, эрүүл аюулгүй орчин бүрдэнэ.

2.6.Автомашины зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлж, авто зогсоолуудыг тохижуулснаар оршин суугч иргэдийн сэтгэл ханамж дээшилж, амьдралын нөхцөл сайжирна.

Зорилт 3: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний стратеги төлөвлөгөө, “Улаанбаатар хотын цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө”-тэй уялдуулан нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

3.1.Айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулах санал санаачилгыг дэмжин урамшуулж, иргэд, хувийн хэвшлийн оролцоотойгоор ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, хотын өнгө үзэмжийг сайжруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

3.2.Худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий тусгай бүс, төрөлжсөн байршлуудад үйлдвэрлэл үйлчилгээ явуулах бичил, жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлэх;

3.3.Хүүхэд залуучууд, ахмад настнуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх биеийн тамирын талбай, хүүхдийн тоглоомын талбай, эко орчин бүхий бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тоог нэмэгдүүлэх;

3.4.Байгаль орчноо хамгаалах, хүрээлэн буй орчинд ээлтэй иргэн бий болгох чиглэлээр ЕБС-ийн сурагчид, хүүхэд, багачууд, өсвөр үе, залуучууд, ахмад настнуудад зориулан сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулах;

3.5.Дүүргийн нутаг дэвсгэрт “Мод үржүүлгийн төв”-ийг байгуулж, мэргэжлийн байгууллага, дендрологичтой хамтран ажиллаж, мод үржүүлэх, нийтийн эзэмшлийн талбайд шилжүүлэн суулгах, арчлалт хамгаалалтын ажлыг сайжруулах;

3.6.Мод, ногоон байгууламжийг бүртгэлжүүлэн, бүртгэл мэдээллийн санг үүсгэх;

Хүрэх үр дүн:

3.1.Ногоон байгууламж, зүлэг мод нэмэгдсэнээр агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр болж, иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөө буурна.

3.2.Худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ явуулах бичил, жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн ажлын байрыг нэмэгдэж, айл өрхийн амьжиргаа дээшилнэ.

3.3.Хүүхэд залуучууд, ахмад настнуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломж нэмэгдэнэ.

3.4.Хүүхэд багачууд байгаль орчноо хамгаалах, хүрээлэн буй орчиндоо ээлтэй иргэн болж төлөвшинө.

3.5.Мод үржүүлгийн ажлыг дүүрэгт хэрэгжүүлснээр дүүргийн ногоон байгууламж нэмэгдүүлэх ажил эрчимжинэ.

3.6.Мод, ногоон байгууламжийг бүртгэлжүүлсэнээр мод болгоныг арчилж хамгаалах болон бусад судалгаанд суурь мэдээлэл бүрдэнэ.

Зорилт 4:Дүүргийн нутаг дэвсгэрт гудамж, нийтийн эзэмшлийн талбайг гэрэлтүүлгээр бүрэн хангаж, иргэдийг аюулгүй амар тайван амьдрах нөхцөлөөр хангана.

4.1.Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, ухаалаг системээр үе шаттай сольж шинэчлэх ажлыг хэрэгжүүлэх;

4.2.Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн асалтад хяналт тавьж, үзлэг шалгалт хийж, тогтмол асааж ажиллах;

Хүрэх үр дүн:

4.1.Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийг эрчим хүчинд хэмнэлттэй, ухаалаг системээр холбосноор цахилгаан эрчим хүчний хэрэглээ багасч, гэрэлтүүлгийн тусгал нэмэгдэж, үзэгдэх орчин сайжирна.

4.2. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн асалтын чанар сайжирч, тогтмолжиж, иргэдийн гомдол, санал буурна.

Зорилт 5: Агаар, орчин бохирдуулагч эх үүсвэрийг бууруулж, байгальд ээлтэй хэрэглээг нэмэгдүүлнэ.

5.1. Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл, тооллогын ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, яндан буулгах, агаар бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах ажлыг хэрэгжүүлэх;

5.2. НҮБХХ-тэй хамтран гэр хорооллын 100 хүртэлх айл өрхөд сэргээгдэх эрчим хүчинд түшиглэсэн халаалтын төхөөрөмж суурилуулах ажлыг зохион байгуулах;

5.3. Гэр хорооллын айл өрхийн гэр, байшин сууцын дулаан алдагдлын судалгаа, шинжилгээг хийж, дулаан алдагдлыг бууруулах ажлыг хэрэгжүүлэх;

5.4. Гэр хорооллын айл өрхийн жорлон, бохирын цооногийг буулгаж, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, цэвэр бохир усны нэгдсэн системд холбох ажлыг зохион байгуулах;

5.5. Дүүргийн нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж байгууллагуудын нэгдсэн бүртгэл, мэдээллийг шинэчлэн бүрдүүлэх, хог хаягдлын гэрээг шинэчлэн хийх, олон нийтийн байцаагчдыг томилж ажиллуулан хог хаягдлын хураамж, орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

5.6. Хог хаягдлыг тээвэрлэх ажлыг шөнийн цагт шилжүүлэх шинэлэг менежментийг нэвтрүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх;

5.7. Ухаалаг хогийн савыг үе шаттайгаар байршуулах ажлыг үүсмэл хогийн цэгтэй байшин хорооллоос эхэлж, цаашид гэр хорооллын бүсэд нэмэгдүүлэх;

5.8. Хог хаягдал ангилан ялгах, дахин боловсруулах үйл ажиллагааг хэрэгжүүлснээр байгальд хаягдах хог хаягдлын хэмжээ багасгах;

5.9. Дүүргийн нутаг дэвсгэр дэх хөрсний чанар, бохирдлын байдалд мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж судалгаа, дүгнэлт гаргуулах;

Хүрэх үр дүн:

5.1. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгааг бодитой, үнэн зөв авснаар агаарын бохирдлыг бууруулахад шаардлагатай арга хэмжээг авах, төлөвлөх, хэрэгжүүлэх үндэс суурь бүрдэнэ.

5.2. Сэргээгдэх эрчим хүчний нөөц боломжийг ашигласнаар цахилгаан эрчим хүчний дутагдлаас сэргийлж, хямд хялбар эрчим хүчээр хангагдах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.3. Гэр хорооллын айл өрх дулаан алдагдлаа бууруулснаар халаалтын зардал багасаж, ая тухтай амьдрах орчин нөхцөл бүрдэнэ;

5.4.Гэр хорооллын нүхэн жорлонгийн тоог цөөлснөөр хөрсний бохирдлыг бууруулах боломж бүрдэнэ.

5.5.Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн бүртгэл, мэдээллийн санг сайжруулж, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хураан төвлөрүүлэх хэмжээг нэмэгдүүлэн, дүүргийн төсөвт ирэх орлогыг нэмнэ.

5.6.Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, цагийн зохицуулалттай хог тээвэрлэх, худалдан авах ажлыг хэрэгжүүлснээр цэвэр хот, цэвэр орчин бүрдүүлэхэд нэг шат ахина.

5.7.Хог ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах нөхцөл боломж нэмэгдэж, иргэдийн ухамсар дээшилж, хогны хаягдал багасна.

5.8.Хог хаягдал ангилан ялгах, дахин боловсруулах үйл ажиллагааг хэрэгжүүлснээр байгальд хаягдах хог хаягдлын хэмжээ багасна.

5.9.Дүүргийн нутаг дэвсгэр дэх хөрсний чанар, бохирдлын байдалд мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж судалгаа, дүгнэлт гаргуулснаар хөрсний бохирдлыг бууруулах байршлыг оновчтой тогтоож, зөв төлөвлөлт хийгдэнэ.

Зорилт 6:Дүүргийн нутаг дэвсгэр дэх инженерийн дэд бүтцийг сайжруулах, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлнэ.

6.1.Үерийн болон хөрсний ус зайлуулах байгууламжийг нэмэгдүүлж, засвар шинэчлэлтийн ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх

6.2.Нийтийн тээврийн тохижилт хийгдээгүй, дундын болон эцсийн зогсоолуудыг сүүдрэвч болон дулаан саравч бүхий тохижилттой болгож зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх;

6.3.Гэр хорооллын дундах авто зам, автобусны буудлын зорчих хэсгийг өргөтгөн шинэчилж, нийтийн тээврээр зорчих боломжийг бүрдүүлэх;

6.4.Дүүргийн нутаг дэвсгэр дэх цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй болон эрчим хүчний уналттай айл өрхийг найдвартай эрчим хүчинд холбох, хүчдэлийн уналтыг бууруулах;

Хүрэх үр дүн:

6.1.Үерийн болон хөрсний ус зайлуулах байгууламжийг нэмэгдүүлснээр айл өрх, аж ахуйн нэгжийг үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

6.2.Нийтийн тээврийн зогсоолын хүртээмж нэмэгдэж, нийтийн тээврээр үйлчлүүлэгчдийн хүндрэлгүй, шуурхай үйлчлүүлэх боломж хангагдана.

6.3.Гэр хорооллын иргэд нийтийн тээврээр ая тухтай зорчих боломж бүрдэнэ.

6.4.Дүүргийн нутаг дэвсгэр дэх цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй болон эрчим хүчний уналттай айл өрхийн тоо буурсан байна.

Дөрөв.Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

“Тохилог Чингэлтэй - 2028” арга хэмжээг 2024-2028 оны хооронд хэрэгжүүлэх бөгөөд арга хэмжээг дараах эх үүсвэрүүдээс санхүүжүүлнэ.

- Улсын төсөв
- Нийслэлийн төсөв
- Дүүргийн төсөв
- Төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа
- Олон улсын байгууллагын дэмжлэг, хандив тусламж
- Төсөл хөтөлбөрийн санхүүжилт

Тав.Арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт

- Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар
- Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс
- Агаар орчны бохирдолтой тэмцэх тасаг
- Гадаадын төсөл, хөтөлбөрүүд
- Гүйцэтгэгч байгууллагууд
- Төрийн бус байгууллага
- Иргэд
- Аж ахуйн нэгж

Зургаа.Арга хэмжээний хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт

Тус арга хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам батлах тухай” 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллана.

Хөтөлбөр хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт хийснээр цаашид сайжруулан, анхаарч ажиллах чиглэлийг тодотгон дүүргийн холбогдох байгууллагуудад танилцуулан жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөлтөд тусган ажиллана.

Хяналт-шинжилгээ үнэлгээг Чингэлтэй дүүргийн Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс зохион байгуулж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Явцын дотоод үнэлгээ (жилд 2 удаа) - хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол удирдлагаар хангахад дэмжлэг үзүүлэн, тулгарсан бэрхшээлийг тодорхойлж сайжруулалт хийх, ахицыг үнэлэх
- Хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээ (2026 онд) - Хүрсэн үр дүн, бэрхшээлийг тооцож сайжруулах гарцыг тодорхойлж, шаардлагатай бол зорилт, үйл ажиллагаанд тодотгол хийх
- Хөтөлбөрийн эцсийн үнэлгээ (2028 онд) - үйл ажиллагааны тоон чанарт бус, бодит үр дүн, эерэг нөлөөнд суурилсан үнэлгээ хийх, цаашдын бодлого төлөвлөлтөд оруулах саналыг боловсруулах

Шалгуур үзүүлэлт:

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин			
			2025 он	2026 он	2027 он	2028 он
Зорилт 1.Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, дээвэр, фасад, инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчилж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.						
1.1.Дээвэр засвар хийх шаардлагатай нийтийн зориулалттай орон сууцны тоо	тоо	43	63	73	79	83
1.2.Фасад засвар хийх шаардлагатай нийтийн зориулалттай орон сууцны тоо	тоо	35	65	75	85	94
1.3.Цахилгаан шат, инженерийн шугам, сүлжээний засвар, шинэчлэлт хийх шаардлагатай нийтийн зориулалттай орон сууцны тоо	тоо	5	8	10	13	15
Зорилт 2.Авто зам, замын гүүрэн байгууламж, үндсэн сүлжээ, тойрог болон туслах зам, замын ус зайлуулах шугам сүлжээний шинэчлэлтийн ажил, зам засварлах ажлуудыг хэрэгжүүлнэ.						
2.1.Дүүргийн хэмжээнд шинээр хийгдсэн авто зам, замын байгууламж	км	137,5	139,5	141,5	143,5	145,2
2.2.Дүүргийн хэмжээнд шинээр хийгдсэн авто замын гүүрэн байгууламж	тоо	32	33	34	35	36
2.3.Авто замын ус зайлуулах шугам сүлжээний засварын ажлын хэрэгжилт	метр	1000	1200	1400	1600	1800

5.1.Агаарын бохирдлын эх үүсвэрийг бууруулах ажлын хэрэгжилт	хувь	20	50	70	90	95
5.2.Сэргээгдэх эрчим хүчний дэвшилтэт технологи нэвтрүүлсэн айл өрх	тоо	0	100	200	300	400
5.3.Гэр хорооллын айл өрхийн сууцын дулаан алдагдлыг бууруулах чиглэлээр хийгдсэн ажлын хэрэгжилт	тоо	0	4000	6000	8000	10000
5.4.Нүхэн жорлон, бохир усны цооногийг буулгаж ариутгал, халдваргүйтгэл хийсэн айл өрх	Тоо	1619	1800	1900	2000	2100
5.5.Хог хаягдлын хураамж, орлого төвлөрүүлэлтийн орлогын хэмжээ	төгрөг /тэрбум/	1,5	3,0	3,0	4,0	5,0
5.6.Хог хаягдлыг тээвэрлэх ажлыг шөнийн цагт шилжүүлэх менежментийн хэрэгжилт	хувь	0	100	100	100	100
5.7.Ухаалаг хогийн савны тоо	тоо	2	26	34	42	50
5.8.Хог хаягдал ангилан ялгах, дахин боловсруулах үйл ажиллагааны цэг	Тоо	2	4	5	6	7
5.9.Дүүргийн нутаг дэвсгэр дэх хөрсний чанар, бохирдлын байдалд мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж судалгаа, дүгнэлт	Тоо	0	0	1	1	1
Зорилт 6.Дүүргийн нутаг дэвсгэр дэх инженерийн дэд бүтцийг сайжруулах, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлнэ.						
6.1.Үерийн болон хөрсний ус зайлуулах байгууламж	м	1400	1600	1800	2000	2200
6.2.Нийтийн тээврийн зогсоолуудын тохижилтын ажил хэрэгжсэн байршил	тоо	38	39	40	41	42
6.3.Гэр хорооллын дундах авто зам, автобусны буудлын зорчих хэсгийг өргөтгөн шинэчилсэн байршил	тоо	2	3	4	5	6
6.4.Дүүргийн нутаг дэвсгэр дэх цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй болон эрчим хүчний уналттай айл өрхийг найдвартай эрчим хүчинд холбох, хүчдэлийн уналтыг буурсан айл өрх	тоо	276	326	376	426	476